



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A/566

Булган сум

### Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны A/343 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 1.7 км /Булган, Сайхан сум/-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан "Авто замын машин механизм" ХХК-тай 1 499 710 997 (нэг тэрбум дөрвөн зуун ерэн есөн сая долоон зуун арван мянга есөн зуун ерэн долоо) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Сайхан сумын Засаг дарга (Д.Сансар-Очир)-д үүрэг болгосугай.

4. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Авто замын машин механизм" ХХК-ийн захирал (А.Гантулга)-д даалгасугай.

5. Хавсралтад заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусгаж, хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

БАРИУН-ЭРДЭНЭ



6324010768

Аймгийн Засаг даргын 20<sup>24</sup>. оны  
08 дугаар сарын 02-ний өдрийн 14:56 дугаар  
захирамжийн хавсралт

№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	Магадлашгүй ажил	25,580,378	Ү.Бямбасүрэн
2	Техник, технологийн хяналт, зөвлөх үйлчилгээний зардал	56,448,868	Ү.Бямбасүрэн
3	Захиалагчийн хяналтын зардал	5,644,887	Ү.Бямбасүрэн
4	Норм, нормативын сангийн шимтгэл	5,116,076	Ү.Бямбасүрэн
5	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Д.Батцогт
6	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
7	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 441 хоног	Ү.Бямбасүрэн